



АГУУЛГА

1	Үйлдвэрийн товч танилцуулга.....	2
1.1	Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл.....	2
1.2	Хүчин чадал.....	2
1.3	Үндсэн үйл ажиллагаа.....	2
1.4	Ажиллах горим, ажилчдын тоо.....	2
2	Хог хаягдлын өнөөгийн байдал.....	3
2.1	Хог хаягдлын тоо хэмжээ.....	3
2.2	Хог хаягдлын төрөл.....	6
2.3	Хог хаягдал зайлуулж буй арга хэмжээ.....	8
3	Хог хаягдалтай холбоотой хууль эрх зүйн орчин.....	9
3.1	УИХ болон Засгийн газрын тогтоол.....	9
3.2	Сайдын тушаал, шийдвэр.....	10
3.3	ИТХ-ын тогтоол.....	11
4	Хог хаягдлын менежментийг сайжруулах арга хэмжээ.....	12
4.1	Хог хаягдалтай холбоотой удирдлага зохион байгуулалт.....	12
4.2	Хог хаягдлын ангилан ялгалт.....	13
4.3	Хог хаягдлыг түр хадгалах цэгийг сайжруулан тохижуулах санал.....	14
4.3.1	Оффисын барилгуудын хог хаягдлын ангилал.....	14
4.3.2	Хог хаягдал түр хадгалах цэгүүдийн байршил, хуваарилалт.....	15
4.3.3	Хог хаягдал түр хадгалах цэгүүдийн загвар, хэмжээс.....	18
4.3.4	Төвлөрсөн хог хаягдал хадгалах цэгийн байршлыг тогтоож, зохион байгуулалт.....	19
4.4	Ангилсан хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж.....	21
5	Хог хаягдлаас Байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл.....	26
6	Дүгнэлт.....	33



1 ҮЙЛДВЭРИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Уг бүлэгт үйлдвэрийн хүчин чадал, үйл ажиллагааны чиглэл, бүтэц зохион байгуулалтын талаарх мэдээллийг товч оруулсан болно.

1.1 Төсөл хэрэгжүүлэгчийн ерөнхий мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч-“Дулааны 3-р Цахилгаан Станц” ТӨХК

Тусгай зөвшөөрөл-Дулаан, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл, хангах, түгээх, худалдах

1.2 Хүчин чадал

1966 оны 12-р сарын 3-ны өдөр Дулааны 3-р цахилгаан станцын суурь тавигдаж, 1968 оны 12-р сарын 10-нд анхны зуух ашиглалтад орж, нийслэл хотын албан байгууллага, орон сууцанд дулааны эрчим хүч түгээж эхэлжээ. Өнөөдрийн байдлаар уг станцын суурилагдсан хүчин чадал цахилгаанаар 198 МВт, дулаанаар 585 Гкал байна.


1.3 Үндсэн үйл ажиллагаа

Тус цахилгаан станц дараах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:

1. Цахилгаан үйлдвэрлэх
2. Цахилгаан түгээх
3. Дулаан үйлдвэрлэх
4. Дулаан түгээх
5. Цахилгаанаар зохицуулалттай хангах
6. Дулаанаар зохицуулалттай хангах

1.4 Ажиллах горим, ажилчдын тоо

Нийт 995 ажилчдаас ИТА 205, ажилчид 781 хүн, үүнээс дээд боловсролтой 383, тусгай дунд 97, бүрэн дунд 434 ажиллаж байна. Үйлдвэр нь өдрийн болон ашиглалтын 4 ээлжийн зохион байгуулалтаар ажилладаг. Зуны улиралд 85-90 хүн, өвөл 120-135 хүн тус тус ажилладаг байна.





2 ХОГ ХАЯГДЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Уг бүлэгт “Дулааны 3-р Цахилгаан Станц” ТӨХК –иас гарч буй хог хаягдлын хэмжээ, төрөл, хэрхэн зайлуулж буй байдлын талаар товч мэдээллийг бэлтгэн оруулав.

2.1 Хог хаягдлын тоо хэмжээ

“ДЦС-3” ТӨХК өмнө нь хог хаягдлын ерөнхий бүртгэл хөтөлдөг ба ангилан ялгалт хийхгүйгээр нийт хог хаягдлын тоо хэмжээг гаргаж байна. Үүнд:

- 2018 онд дунджаар 3200тн
- 2019 онд дунджаар 2503 тн хог хаягдлыг тээвэрлэн зайлуулсан.

Одоогийн байдлаар дунд буюу өндөр даралтын станцад үйлдвэрийн хог хаягдалд зориулан 9 бункер, бусад барилга байгууламжуудын дунд 5 бункер байна. Одоо байгаа бункерын байршил, фото зургийг доор үзүүлэв.

Одоогийн ашиглах байгаа хог хаягдал түр хадгалах бункерын фото

Бункер 1



Бункер 2



Бункер 3



Бункер 4



Бункер 5



Бункер 6 /дунд болон өндөр даралтын





станцад байгаа 6 ширхэг бункерын
төлөөлөл/





Одоогийн хог хаягдал хаяж буй бункерт дараах болзошгүй эрсдэл, сөрөг нөлөөллүүд ажиглагдаж байна.

1. Хог хаягдлыг ангилан ялгах боломжгүй
2. Хог хаягдлын бункер руу гарч байгаа шат нь төмрөөр хийгдсэн нарийн тавцантай тул шатнаас ажилчид шатнаас унаж, хальтирч болзошгүй байна.
3. Хэрэв бункерт овор хэмжээ болон жин ихтэй (хатуу төмөр, модон) хог хаягдал хаясан тохиолдолд уг бункерээс хог хаягдлыг гаргаж буй хүн тухайн хаягдалд цохиулан гэмтэж бэртэж болзошгүй.
4. Бункер нь хэт өндөрт байрлах тул бункерын гагнаас салж унах эрсдэл үүсэж болзошгүй.



ДУЛААНЫ III ЦАХИЛГААН СТАНЦЫН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ОДООГИЙН БУНКЕРУУДЫН БАЙРШИЛ



Ид	Эх үүсвэрүүд	Хувий тоо
1	Бөмөр сарлагын станцын барилга	10
2	ДЭД-дариулалын станцын барилга	56
3	ПШУ-1/2-ийн барилга, хэст	5
4	Ариулагч барилга	1
5	Өмчийн хураалтын өмчийн барилга	45
6	Авардас өсгөр	-
7	Бүтээгдэхүүнийг Зарлиг	9
8	Хяруулын БЭР №1-8	5
9	Батрын өмчийн барилга	110
10	Өмчийн барилга	4
11	Өмчийн байр	-
12	А.У.С. өмчийн барилга/ийн барилга	26
13	Насосхүдэн байр	-
14	Хөлийн цөөмөр - Зарлиг	30
15	Мэсэлэн цөөмөр - Зарлиг	58
16	Ариулагч, өмчийн өмчийн өмчийн барилга	15
17	Ш.Хөлийн цөөмөр	-
18	Батрын өмчийн барилга	4
19	Мэсэлэн өмчийн барилга	4
20	Авардас өмчийн барилга	-
21	А.У.С. өмчийн барилга	-
22	Угсаа дагалдагч - 4	-
23	ДЭД-ийн нүүрс буталч - Зарлиг	-
24	ДЭД-ийн удирдах шатны барилга	-
25	ДЭД-ийн өмчийн барилга	100
26	Батрын өмчийн барилга	-
27	Батрын өмчийн барилга	-
28	Батрын өмчийн барилга	-
29	Батрын өмчийн барилга	110
30	Хүрээтэй өмчийн барилга	1

Эх үүсвэрүүд	Хувий тоо	
31	Төмрийн 4 БЭ өмчийн барилга	-
32	Ариулагч өмчийн барилга	10
33	Ариулагч өмчийн барилга	10
34	Ариулагч өмчийн барилга	25
35	Ариулагч өмчийн барилга	-
36	Ариулагч өмчийн барилга	-
37	Ариулагч өмчийн барилга	-
38	Ариулагч өмчийн барилга	15
39	Ариулагч өмчийн барилга	3
40	Ариулагч өмчийн барилга	1
41	Ариулагч өмчийн барилга	2
42	Ариулагч өмчийн барилга	-
43	Ариулагч өмчийн барилга	15

Уурээ
Боловсруулсан
Хямсан

Овоо, нэр

Байгаль Талалт ХХК



2.2 Хог хаягдлын төрөл

Эх үүсвэрээс ямар төрлийн хог хаягдал гарч байгааг дараах хүснэгтээр үзүүлэв.

Хог хаягдлын төрөл

Дд	Эх үүсвэрүүд	Хүний тоо	Хог хаягдлын төрөл											
			1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
			Үнс, шаарга	Төмөр	Мод	Өвс	Хоолны үлдэгдэл	Хуванцар сав	Гялгар уут	Шил, Лааз	Цаас	Хувцас, даавуу	Химийн сав баглаа боодол	Ангилдаагүй хаягдал
1	Өндөр даралтын станцын барилга	90	+	+	+	+		+	+	+	+	+		+
2	Дунд даралтын станцын барилга	55		+	+	+		+	+	+	+	+		+
3	ГШУ-1-ийн барилга, мост	5						+	+	+	+	+		
4	Архивын барилга	1						+	+	+	+			
5	Соёлын хүмүүжлийн төвийн барилга	45				+	+	+	+	+	+			+
6	Хоргодох байр	-		+	+	+								
7	Сургалтын төвийн барилга	2						+	+	+	+	+		
8	Харуулын байр №1—8	5						+	+	+	+	+		
9	Захиргааны барилга	150					+	+	+	+	+	+		+
10	Эмнэлгийн барилга	4						+	+	+	+	+		
11	Фкалын байр	-												
12	Авто аж ахуйн хэсгийн барилга	24		+	+	+		+	+	+	+	+		
13	Насосуудын байр	-		+										
14	Хими цехийн барилга	35		+	+	+		+	+	+	+	+	+	+
15	Механик цехийн барилга	58		+	+	+		+	+	+	+	+		+
16	Хүнд машин, механизмын аж ахуйн барилга	25		+	+	+		+	+	+	+	+		+
17	Шатахуун түгээгүүр	-		+										
18	Багер аж ахуйн барилга	4	+	+		+		+	+	+	+	+		+
19	Мазут аж ахуйн барилга	4		+	+	+		+	+	+	+	+		+
20	Аваарын нөөцийн агуулахын барилга	-		+	+									
21	Авто машины гражийн барилга	-		+	+									
22	Туузан дамжуулагч 1-14			+	+			+	+	+	+	+		



23	ТДЦ-ийн нүүрс бутлагчийн барилга	100		+	+			+	+	+	+	+		
24	ТДЦ-ийн удирдах шитний барилга			+	+			+	+	+	+	+		
25	ТДЦ-ийн ахуйн ба конторын барилга							+	+	+	+	+		
26	Вагон пүүний барилга							+	+	+	+	+		
27	Вагон хөмрөгч А, Б барилга							+	+	+	+	+		
28	Вагон гэсгээгчийн барилга							+	+	+	+	+		
29	Лабораторийн төв барига	110		+	+	+	+	+	+	+	+	+		+
30	Хүчилтөрөгч аж ахуйн барилга	1						+	+	+	+	+		
31	Техникийн ба аж ахуйн агуулахын барилга	-						+	+	+	+	+		
32	Ахуйн ба конторын барилга	50			+			+	+	+	+	+		
33	Цахилгааны реле хамгаалалтын барилга	25						+	+	+	+	+		
34	Ахуйн бас конторын барига	25						+	+	+	+	+		
35	Эргэлтийн усны насосын барилга	-						+	+	+	+	+		
36	Ус хөргөгч цамхагийн байгууламж	-												
37	Брызгалын бассейн	-												
38	Цахилгаан цехийн засвар ба ахуйн барилга	15		+	+	+		+	+	+	+	+		
39	Дотоод хэрэгцээний цах/хув барилга	2						+	+	+	+	+		
40	Дотоо хэрэгцээний халаагчийн барилга	1						+	+	+	+	+		
41	Ил хувиарлах байгууламж	2			+	+		+	+	+	+	+		
42	Хуучин сэлбэгийн хашаа	-		+	+	+								
43	Уурын хэсгийн засварын барилга	15		+	+	+		+	+	+	+	+		
	Нийт	853												



2.3 Хог хаягдал зайлуулж буй арга хэмжээ

Ахуйн хог хаягдлыг ангилалгүй өөрийн машинаар тээвэрлэн Морингийн давааны хогийн цэгт хүргэн зайлуулж байна.

Байгууламжуудыг холбоосон 5 бункер, өндөр буюу дунд даралтын зуухнуудад 6 бункер тус тус байна. Бункерын багтаамж ойролцоогоор 1 x 1.5м байна.

2019 онд 2503 тн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт асгахын тулд том ачааны машинаар 188 удаа 8272 км зайд 3440.4 л шатахуун, жижиг ачааны машинаар 202 удаа 8888 км зайд 2155.3 л шатахуун зарцуулсан бөгөөд нийт зардал 17.3 сая төгрөг зарцуулсан байна.

Хог хаягдлын тээвэрлэн зайлуулах ажлын зардал, 2019 он

Ангилал	Автомашин		Нийт
	Том	Жижиг	
Шатахууны норм 100 км	41.67 л	24.27 л	
Хогийн цэг нэг талдаа 22 км	44 км /18.3 л	44 км / 10.67 л	
2019 оны 11-р сарын явсан, ирсэн тоо	1-р сар	16 удаа	17 удаа
	2-р сар	18 удаа	25 удаа
	3-р сар	25 удаа	20 удаа
	4-р сар	10 удаа	18 удаа
	5-р сар	13 удаа	20 удаа
	6-р сар	18 удаа	14 удаа
	7-р сар	13 удаа	20 удаа
	8-р сар	20 удаа	15 удаа
	9-р сар	21 удаа	16 удаа
	10-р сар	15 удаа	18 удаа
	11-р сар	19 удаа	19 удаа
	12-р сар		
Нийт	188 удаа	202 удаа	390 удаа
Нийт явсан зай км	8272 км	8888 км	17160 км
Зарцуулсан шатахууны нийт хэмжээ	3440.4 л	2155.3 л	5595.7 л
Шатахууны үнэ литр	2080 төгрөг	2080 төгрөг	
Зарцуулсан шатахууны нийт зардал	7,156,032 төгрөг	4,483,024 төгрөг	11,639,056 төгрөг
Нийт хогны хэмжээ	2503 тн		
Хогны төлбөр / НӨАТ /-тэй	5,726,240 төгрөг		
Нийт зардал	17,365,296 төгрөг		

Эх сурвалж: ДЦС-3 ТӨХК-ийн Техникийн бодлогын хэлтэс



3 ХОГ ХАЯГДАЛТАЙ ХОЛБООТОЙ ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Хог хаягдлын тухай хууль нь 2017 онд батлагдсан ба хуулинд нийцүүлэн 18 журам аргачлалыг баталсан байна. Дараах хүснэгтэд хог хаягдалтай холбоотой гарсан ЗГ-ын тогтоол, Сайдын тушаал, НИТХ-ын тогтоолуудыг нэгтгэж оруулав.

3.1 УИХ болон Засгийн газрын тогтоол

д/д	Тогтоолын нэр	Тогтоолын дугаар	Батлагдсан огноо
1	Хууль		
	1.1	Хог хаягдлын тухай хууль	2017.05.12
2	Хөтөлбөр		
	2.1	Хог хаягдлыг бууруулах тухай хөтөлбөр	50 1999.03.24
	2.2	Хог хаягдлын менежментийг сайжруулах үндэсний хөтөлбөр	298 2014.09.18
3	Журам, жагсаалт		
	3.1	Байгальд ээлтэй, дэвшилтэт арга, технологи нэвтрүүлсэн иргэн аж ахуйн нэгж, байгууллагыг урамшуулах журам.	290 2017.09.27
	3.2	Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам	116 2018.05.02
	3.3	Аюултай хог хаягдлын жагсаалт	116 2018.05.02
	3.4	Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай	189 2018.06.20
	3.5	Монгол улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалтанд нэмэлт оруулах.	199 2019.05.22



3.2 Сайдын тушаал, шийдвэр

Байгаль орчин аялал жуулчлалын сайд болон Сангийн сайдын хамтарсан тушаал, шийдвэрүүдийг дараах хүснэгтэд нэгтгэн оруулав.

д/д	Тушаалын нэр	Дугаар	Батлагдсан огноо
1	Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал. /Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаал.1-р хэвсрэлт/	192 А/243	2018.07.19
2	Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, булшлах зардлын нэгж тарифыг тооцох аргачлал. /Сангийн сайд, Байгаль орчин аялал жуулчлалын сайдын хамтарсан тушаалын 2-р хэвсрэлт/	192 А/243	2018.07.19
3	Үүсэх хог хаягдлыг үйлдвэрлэгч болон импортлогч хариуцах зарим бүтээгдэхүүний жагсаалт. /Байгаль орчин аялал жуулчлалын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал/	А-429/257	2018.11.13
4	Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	А/349	2017.12.12
5	Энгийн хог хаягдлын норматив хэмжээг тогтоох аргачлал. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	А/368	2017.12.25
6	Журам батлах тухай. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	А/18	2018.01.31
	— Аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах, экспортох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагад зөвшөөрөл олгоход тавигдах шаардлага болон зөвшөөрөл олгох журам. /1-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал экспортлох өргөдөл. /2-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх түр зөвшөөрөл. /3-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал экспортлох зөвшөөрөл. /4-р хэвсрэлт/	-	
7	Маягт батлах тухай. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	А/21	2018.02.02
	— Аюултай хог хаягдлын дагалдах бичиг. /1-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал үүсгэгч болон тээвэрлэх, цуглуулах, дахин боловсруулах, устгах, экспортлох үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгжийг бүртгэх бүртгэлийн хуудас. /2-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал үүсгэгчийн тайлангийн маягт. /3-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал тээвэрлэгчийн тайлангийн маягт. /4-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал цуглуулах үйл ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягт. /5-р хэвсрэлт/	-	
	— Аюултай хог хаягдал дахин боловсруулах үйл	-	



д/д	Тушаалын нэр	Дугаар	Батлагдсан огноо
	ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягт. /6-р хэвсралт/		
	— Аюултай хог хаягдал сэргээн ашиглах үйл ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягт. /7-р хэвсралт/	-	
	— Аюултай хог хаягдал устгах /ландфилд булшлах, биологийн, хими физикийн аргаар боловсруулах, шатаах, халдваргүйжүүлэх, савлаж хадгалах/ үйл ажиллагаа эрхлэгчийн тайлангийн маягт. /8-р хэвсралт/	-	
	Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	A/21	2018.11.12
8	Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах, үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	A/443	2018.11.17
9	Маягт батлах тухай. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	A/444	2018.11.19
	— Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэгчийг бүртгэх бүртгэлийн хуудас. 1-р хэвсралт	-	
	— Энгийн хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааны тайлан /нэгтгэл/. 2-р хэвсралт	-	
10	Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулах, үйл ажиллагаа явуулах, хаах аргачилсан заавар. /Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын тушаал/	A/445-р	2018.11.19
11	Барилгын хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, ангилах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам. /Барилга, хот байгуулалтын сайдын тушаал/	48	2020.02.27

3.3 ИТХ-ЫН ТОГТООЛ

Тогтоолын нэр	Дугаар	Батлагдсан огноо
Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам /Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурал/	32/03	2020.02.20



4 ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Хог хаягдлын менежментийг сайжруулснаар хог хаягдлаа ангилан ялгаж дахин боловсруулах үйлдвэрт тушаах боломжтой болох бөгөөд ингэснээр хог хаягдлыг тээвэрлэн, зайлуулах урсгал зардал буурч байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөө багасах болно.

Хог хаягдлын менежментийг сайжруулах санал, зөвлөмжийг дараах 4 хэсэгт ангилан бэлтгэв. Үүнд:

1. Хог хаягдалтай холбоотой удирдлага, зохион байгуулалт
2. Хог хаягдлын ангилан ялгалт
3. Хог хаягдлын түр хадгалах цэгүүдийг сайжруулах санал
4. Ангилан ялгасан дахивар хаягдлыг эдийн засгийн эргэлтэнд оруулах

4.1 Хог хаягдалтай холбоотой удирдлага зохион байгуулалт

Байгууллагын удирдлагын түвшинд хог хаягдалтай холбоотой дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

- Жил бүр боловсруулж батлуулдаг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд /БОМТ/ хог хаягдалтай холбоотой шийдэх асуудлуудаа тусгаж нэвтрүүлэх
- Ажилчдад үүсэж болох хог хаягдлыг аль болох бууруулах, нэгэнт үүссэн хог хаягдлыг дахин ашиглах, хог хаягдлын хор уршгийг ойлгуулах зэрэг чиглэлүүдээр сургалтуудыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх
- Хог хаягдалтай холбоотой ухуулга самбар байршуулж сэдэл өгөх арга хэмжээ хийх
- Хог хаягдалтай холбоотой нийтийг хамарсан нөлөөллийн арга хэмжээ авах
- Алба хэлтэсүүдэд хог хаягдлыг бүртгэлжүүлэх дадлыг хэвшүүлэх

Хаягдлыг багасгах зөвлөмж жишээнүүд:

- Нэг удаагийн бага хэмжээгээр савалсан бүтээгдэхүүнээс татгалзаж том савлагаатай бүтээгдэхүүн сонгох нь хог хаягдлыг багасгана.
- Дэлхий дээр жилд дунджаар 15 сая га модыг устгаж байгаагийн 1/3 нь цаас үйлдвэрлэхэд зарцуулагддаг. Компьютерийг ашиглан бичихдээ 12 үсгийн хэмжээгээр бичихэд хуудасны тоо 57 байсан бол 11 болгож бичихэд хуудасны тоо 51 болж багасна. Мөн цаасны 2 талыг бүрэн ашиглах хэрэгтэй.
- Пластик, резин, хуванцар савнуудыг ангилан түүхий эд дахин боловсруулах газарт тушааж ашигласнаар орчноо бохирдуулахгүй байх боломжтой.
- Хувцас дахин өмсөх боломжгүй болсон бол өөр олон зүйлийг хийж болно. Тухайлбал даавуун тор, бээлий, зөөлөн тоглоом, малын нэмнээ гэх мэт олон зүйлд ашиглах боломжтой.
- Дэлхий дээр хог хаягдлын 30 хувийг гялгар уут эзлэж байна. Гялгар уут ашилахын оронд даавуун уутыг хэрэглэж хэвших



4.2 Хог хаягдлын ангилан ялгалт

НИТХ-ын 2020 оны 32/03 тогтоолоор баталсан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах журам”-ын 6.3-т зааснаар Хог хаягдлыг ангилахдаа дараах өнгөөр ялгахыг заасан байдаг. Иймд ДЦС нь дараах хүснэгтэд харуулснаар ахуйн хог хаягдлаа 7 төрлөөр ангилан ялгаж хэвших нь зүйтэй.

Хог хаягдал хаях ангилал

Д/д	Хог хаягдлын ангилал	Багтах хог хаягдал	Хадгалах савны өнгө
1	Гялгар уут, хуванцар	Төрөл бүрийн ус, ундааны сав, 0.025мм-ээс дээш зузаантай гялгар уут, баглаа боодол, кетчуп, ургамлын тос, бие угаагчшингэн, шампунь, угаалгын шингэний хуванцар сав гэх мэт РЕР, НТРЕ, ЛТPI, РР тэмдэглэгээ бүхий ахуйн болон хүнсний хуванцар савнууд Мөн бүх төрлийн гялгар уут, торнууд	Ногоон
2	Хөнгөн цагаан лааз, металл хаягдал	Ус ундаа болон хүнсний лааз, металл	Улбар шар
3	Цаас	Бичгийн хэмжээний А4-н цаас, Сонин хэвлэлийн бор цаас, цагаан цаас, Дэвтэр, номын цаас, Бүх төрлийн кардон цаас, хайрцаг, Сүү жүүсний тетрапак сав	Цэнхэр
4	Шил	Хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл	Цагаан
5	Хүнсний органик хаягдал	Өндөг, өндөгний хальс, Мах, махан бүтээгдэхүүний хаягдал, Жимс, жимсний хальс, Гурилан бүтээгдэхүүний хаягдал, Хүнсний ногоо, ногооны хальс Хоолны үлдэгдэл	Бор
6	Бусад хог хаягдал	— Ахуйн хэрэглээнээс гарсан салфетка, — нэг удаагийн аяга, таваг, бэлэн хоолны сав гэх мэт хаягдал, — Ариун цэврийн өрөөнөөс гарч буй хаягдал, — Бичиг хэргийн хаягдал /үдээс, CD, фото цаас гэх мэт/	Хар
7	Ахуйн аюултай хог хаягдал	— Засварын газраас гарч байгаа тос, тосолгооноос бохирдсон алчуур, тосны шүүр, ашигласан тос масло — Ашигласан аккумулятор — Химийн бодисын сав баглаа боодол — Ахуйн хэрэглээний бүх төрлийн зай хураагуур буюу баттерей — Бүх төрлийн принтерийн хор	Шар



4.3 Хог хаягдлыг түр хадгалах цэгийг сайжруулан тохижуулах санал

ТӨХК-ий эзэмшлийн газарт нийт 11 ширхэг хог хаягдлын бункер байрлуулж ахуйн гаралтай хог хаягдлаа түр хадгалж байгаа ба үүний 9 нь дунд болон өндөр даралтын станцын барилга дотор, 5 нь гадаа талбайд тус тус байрлаж байна. Одоогоор эдгээр бункеруудад бүх хаягдлыг нийлүүлэн ангилал ялгалт хийхгүйгээр хаядаг, мөн оффисын барилгуудад тусгайлсан ангилсан хогийн сав байддаггүй тул бид дараах зохион байгуулалтыг хийж хог хаягдал хадгалах цэгүүдийг сайжруулахаар төлөвлөсөн болно.

1. Оффисын барилгуудад хог хаягдал ангилан ялгалтыг хэвшүүлэх
2. Хог хаягдал түр хадгалах цэгүүдийн байршлыг тогтоож, хуваарилалтыг хийх
3. Хог хаягдал түр хадгалах цэгүүдийн загвар, хэмжээсийг гаргах
4. Төвлөрсөн хог хаягдал хадгалах цэгийн байршлыг тогтоож, зохион байгуулалт хийх

4.3.1 Оффисын барилгуудын хог хаягдлын ангилал


ТӨХК-ий хүрээнд оффисын ажил эрхэлж буй ажилчдын тоо нь нийт компаний ажилчдын 30 орчим хувийг эзэлдэг. Энэ нь хүний тооноос хамааран гарах хог хаягдлын эзлэх хувьд ч өндөр нөлөөлөхөөр харагдаж байна. Түүнчлэн оффисын барилгуудаас гарах хог хаягдлын дийлэнх хувь нь дахивар хаягдал байх боломжтой ба хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилснаар түүний хэмжээ, үүсэх зардлыг бууруулах ач холбогдолтой. Иймээс оффисын барилгуудын хог хаягдлын ангилалд дараах саналуудыг зөвлөж байна. Үүнд:

- Бүх оффисын барилгуудын давхар тус бүрт хог хаягдлын ангилан ялгалтын савнуудыг 7 төрлөөр байрлуулах
- Хог хаягдлын савнууд нь дээр дурдсан 7 өнгөтэй, хаях хогны зураг эсхүл бичиг бүхий тэмдэг тэмдэглэгээтэй байх
- Хогийн савнууд нь 10-40литрийн багтаамжтай байх
- Хогийн савнууд цоорч гэмтээгүй, угааж цэвэрлэхэд хялбар байх
- Тагтай , хуванцар, эсхүл металл материалаар хийгдсэн байх
- Ажилчдыг хог хаягдлаа ангилан ялгах гарын авлагаар хангаж, зааварчилгаа өгч, хэвшүүлэх арга хэмжээ авах

Загвар болгон зарим байгууллагын хог хаягдлын савны фото зураг оруулав.



Албан байгууллага доторх хог хаягдлын ангилал. /Загвар зураг/





4.3.2 Хог хаягдал түр хадгалах цэгүүдийн байршил, хуваарилалт

Хог хаягдал түр хадгалах цэгүүдийг сонгохдоо алба, хэлтэс, тасгийн үйл ажиллагааны онцлог, байршил, хүний тоог харгалзан үзэж 4 цэг дээр төлөвлөсөн. Түүнчлэн уг 4-н бүсд хувааж цэгүүдэд ямар алба, хэлтэс хог хаях хуваарилатыг дараах зургаар бэлтгэн санал болгов.



САНАЛ БОЛГОХ ХОГ ХАЯГДАЛ ХАДГАЛАХ ТҮР ЦЭГИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



Эх үүсвэрүүд	Хүний тоо
1	90
2	10
3	5
4	1
5	45
6	-
7	2
8	8
9	10
10	4
11	-
12	20
13	-
14	30
15	50
16	20
17	20
18	4
19	4
20	-
21	-
22	10
23	2
24	1
25	3
26	-
27	10
28	-
29	-
30	-
31	-
32	-
33	-
34	-
35	-
36	-
37	-
38	-
39	-
40	-
41	-

Эх үүсвэрүүд	Хүний тоо
1	-
2	50
3	20
4	20
5	-
6	-
7	10
8	2
9	1
10	3
11	-
12	10
13	-
14	-
15	-
16	-
17	-
18	-
19	-
20	-
21	-
22	-
23	-
24	-
25	-
26	-
27	-
28	-
29	-
30	-
31	-
32	-
33	-
34	-
35	-
36	-
37	-
38	-
39	-
40	-
41	-

Үүрэг	Овоо, нэр	Байгаль Тандалт ХХК
Боловсруулсан		
Хянасан		



Үйлдвэрийн бүх барилга байгууламжуудыг ажиллах хүний тоотой нь дараах хүснэгтэд үзүүлж, аль цэг дээр хог хаягдлаа хаях зааврыг өнгөөр ялган харуулав. Үүнийг ялгахдаа тухайн байгууламжуудаас гарах хог хаягдлын төрөл, ажиллах хүний тоотой уялдуулсан болно.

Санал болгож буй хог хаягдал түр хадгалах цэгийн нэгдсэн мэдээлэл

Дд	Эх үүсвэрүүд	Хүний тоо
Хог хаягдал түр хадгалах 1-р бүсэд хамаарах байгууламжууд		
1	Харуулын байр	2
2	Захиргааны барилга	150
3	Эмнэлгийн барилга	4
4	Фкалын байр	-
5	Авто аж ахуйн хэсгийн барилга	24
6	Насосуудын байр	-
7	Багер аж ахуйн барилга	4
8	Мазут аж ахуйн барилга	4
9	Туузан дамжуулагч 1-14	
10	ТДЦ-ийн нүүрс бутлагчийн барилга	
11	Аваарын нөөцийн агуулахын барилга	-
Хог хаягдал түр хадгалах 2-р бүсэд хамаарах байгууламжууд		
12	Химий цехийн барилга	35
13	Механик цехийн барилга	58
14	Хүнд машин, механизмын аж ахуйн барилга	25
15	Шатахуун түгээгүүр	-
16	Туузан дамжуулагч 1-14	
17	ТДЦ-ийн нүүрс бутлагчийн барилга	
18	ТДЦ-ийн удирдах шитний барилга	
19	ТДЦ-ийн ахуйн ба конторын барилга	100
20	Вагон пүүний барилга	
21	Вагон хөмрөгч А, Б барилга	
22	Вагон гэсгээгчийн барилга	
23	Фкалын байр	-
24	Мазут аж ахуйн барилга	4
25	Авто машины гражийн барилга	-
Хог хаягдал түр хадгалах 3-р бүсэд хамаарах байгууламжууд		
26	Лабораторийн төв барига	110
27	Хүчилтөрөгч аж ахуйн барилга	1
28	Техникийн ба аж ахуйн агуулахын барилга	-
29	Ахуйн ба конторын барилга	50
30	Цахилгааны реле хамгаалалтын барилга	25
31	Ахуйн бас конторын барига	25
32	Эргэлтийн усны насосын барилга	-
33	Ус хөргөгч цамхагийн байгууламж	-
34	Харулын байр	
35	Багер аж ахуйн барилга	
36	Хуучин сэлбэгийн хашаа	-
37	Уурын хэсгийн засварын барилга	15
Хог хаягдал түр хадгалах 4-р бүсэд хамаарах байгууламжууд		
38	ГШУ-1-ийн барилга, мост	5
39	Архивын барилга	1
40	Соёлын хүмүүжлийн төвийн барилга	45
41	Хорогдох байр	-
42	Сургалтын төвийн барилга	2
43	Брызгалын бассейн	-
44	Цахилгаан цехийн засвар ба ахуйн барилга	15
45	Дотоод хэрэгцээний цах/хув барилга	2
46	Дотоо хэрэгцээний халаагчийн барилга	1
47	Ил хувиарлах байгууламж	2



4.3.3 Хог хаягдал түр хадгалах цэгүүдийн загвар, хэмжээс

Одоо ашиглаж буй хог хаягдал түр хадгалах хогийн сав буюу бункер нь ангилан ялгалт хийх боломжгүй, их өндөрт байрлуулсан, хогийг хаях, ачихад хүндрэлтэй, хөдөлмөрийн аюулгүй байдлын стандарт, шаардлагыг хангахааргүй байгаа тул хогийн цэгийг дараах байдлаар шинэчлэн сайжруулахаар төлөвлөв.


Хог хаягдал хадгалах савны шатны хэмжээсийг гаргахдаа “Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм. БНБД 31-01-01”-ыг ашигласан болно.

Хог хаягдал түр хадгалах байгууламжийн хэмжээс

Дд	Ангилал	Хэмжээ
1	Хог хаягдлын цэгийн урт	3 м
2	Өндөр	1 м
3	Өргөн буюу гүн	1 м
4	Шатны өргөн	75 см
5	Нэг гишгүүрийн өргөн	25 см
6	Нэг гишгүүрийн өндөр	15-8см
7	Газрын гадаргаас хогийн савны суурь хүртэл	54 см


Хог түр хадгалах цэгийг аль болох хогоо хаях болон ачихад амар, хялбар байх нөхцлийг бодолцож машин орж ачихад бага зэргийн налуутай байх, шат нь газраас их өндөргүй байх хогийн савнууд нь 2 талаасаа онгойдог байх зэргээр төлөвлөсөн. Гэхдээ үүнийг үйлдвэрийн дотоод нөөц бололцоогоо ашиглан өөрсөддөө тааруулж тохируулан хийх бүрэн бололцоотой юм. Хог хаягдлын цэгийн хөндлөн огтлолыг дараах зургаас харна уу.

Хог хаягдал хадгалах түр цэгийн хөндлөн огтлол





Хог хаягдлыг энэ тайлангийн 4.2 –т ангилсан ангилалын дагуу 7 хэсэгт ангилж хогоо ялгаж саванд хийнэ. Хог түр хадгалах цэгийн дэвсгэр зургийг доор харуулав.



4.3.4 Төвлөрсөн хог хаягдал хадгалах цэгийн байршлыг тогтоож, зохион байгуулалт
ТӨХК-ы хашаан дотор **төвлөрсөн хог хаягдал хадгалах** зориулалтаар 1 цэг байгуулах ба энэ нь бусад түр хадагалах цэгүүдээс ирэх хог хаягдлыг ангилан төвлөрүүлж дараагийн шат дамжлага /дахивар боловсруулах үйлдвэр болон хог хаягдлын төвлөрсөн цэг/ -руу явуулахад бэлтгэх газар юм. Уг цэгийн байршлыг зонхилох салхины чиглэлээс хамааруулан, мөн үйлдвэрийн хамгийн сул чөлөөтэй зах газар буюу урьд нь хог хаягдлын бункер байрлуулж байсан газарт сонгосон болно. Төвлөрсөн цэгийн байршлыг дараах зургаас харна уу.

Зураг орж ирнэ



Төвлөрсөн хог хаягдал хадгалах цэгийг үйлдвэрийн ажилчид өөрсдөө дотоод нөөц бололцоогоо ашиглан байгуулж болох бгөөд дараах шаардлагуудыг хангасан байвал зохино. Үүнд:

- Түр хадгалах бусад цэгүүдээс ирж буй хаягдлын төрлөөс багагүй төрлөөр ангилан ялгалт хийж хадгалах
- Хог хаягдал түр хадгалах талбай нь шүүрэл нэвчихээс хамгаалсан хатуу хучилттай байх
- Ангилан ялгалтын сав, тасалгаа нь харахад ойлгомжтой байдлаар тэмдэг тэмдэглэгээтэй байх
- Ангилан ялгалтын сав, тасалгаа нь хог хаягдал салхинд хийсэхээргүй хайс хашлага, түгжээтэй байх
- Хог хаягдал түр хадгалах талбай нь тусгай гэрэлтүүлэгтэй байх
- Хог хаягдал түр хадгалах талбай руу нэвтрэх зам болон хог ачих талбайг тусгайлан засаж тохижуулах
- Талбайд эрүүл ахуйн бүс тогтоож, самбар тэмдэгээр тэмдэгжүүлсэн байх
- Ангилан ялгасан хогийг хооронд нь холихгүй байх
- Дахин ашиглах боломжгүй буюу бусад хог хаягдлыг хамгийн захад нь байрлуулах
- Төвлөрсөн цэгт дахивар хаягдлуудын хэмжээ дүүрсэн тохиолдолд дахивар боловсруулах үйлдвэрүүдэд хүргэх болон дуудаж ачуулах арга хэмжээ авах
- Дахивар хаягдлын хэмжээ, төрлийг ачилт хийх бүрт тэмдэглэн бүртгэл хөтөлж харъяа удирдлагад танилцуулах
- Бусад хог хаягдлыг гэрээт хог хаягдлын төвлөрсөн цэг рүү ачих ба ачилт хийх бүрт тэмдэглэн бүртгэл хөтөлж харъяа удирдлагад танилцуулах

Загвар, жишээ болгох зорилгоор зарим газрын хог хаягдал түр хадгалах төвлөрсөн цэгийн фото зургийг харуулав.



Зарим албан байгууллагын хог хаягдал түр хадгалах төвлөрсөн цэг



4.4 Ангилсан хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж

Дэлхийн банкны 2019 онд хийсэн судалгаагаар Монгол Улсын нэг иргэн өдөрт 2.6 килограмм хог үйлдвэрлэдэг бөгөөд энэ үзүүлэлтээрээ манайх дэлхийд 12 дугаар байрт жагсдаг аж.

Албан байгууллага бүр дахивар буюу дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг ялган ангилж дахин боловсруулах үйлдвэрт өгсөнөөр дараах үр дүнгүүд гарна. Үүнд:

1. Байгаль орчны бохирдлоос сэргийлж, бохирдлыг бууруулна
2. Ажилчид буюу иргэдийг зөв дадал хэвшил, хотын соёлд сургана
3. Байгууллага хог хаягдлаа эдийн засгийн эргэлтэнд оруулах боломж нээгдэж, улмаар урсгал зардал буурна

Улаанбаатар хотын зарим аж ахуйн нэгжүүд хог хаягдлаа ангилан ялгах хогийн савыг ашиглаж, хэвшсэн боловч тэдгээр ангилсан хогийг тээвэрлэдэг автомашин байхгүй учир



ачихдаа нийлүүлээд ачдаг. Харин одоо хотод дахин боловсруулах хогийн тээврийн тогтолцоог нэвтрүүлж эхэлж байна. Энэ нь ангилсан дахивар хаягдлыг үйлдвэрүүдэд хүргэх зориулалт бүхий үйлчилгээ юм.

Дахивар хаягдлыг үйлдвэрүүдэд хүргэдэг машин



Үүнээс гадна иргэдийн ангилсан хогийг дахин боловсруулах үйлдвэрүүдэд хүргэх ажлыг "Царцаа ногоон" дуудлага тээврийн үйлчилгээ үзүүлж байгаа юм. Тус үйлчилгээ нь байгаль орчинд ээлтэй байх үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдсан юм. "Царцаа ногоон" үйлчилгээ нь ахуйн хог хаягдлыг найман төрлөөр ангилан авдаг. Үүнд:

1. PET хуванцар буюу ус ундааны гэрэлтдэг хуванцар сав
2. HDPE хуванцар буюу шампунь, цэвэрлэгээний бодис, шингэн саван, тарагны сав, машины тос, тосолын сав
3. Хөнгөн цагаан-ЛААЗ
4. Гялгар уут
5. PP хуванцар буюу хатуу болон зөөлөн хуванцар
6. Хужирт, Үлэмж, АҮС, АПУ, Урбанек, 100гр СОК-ний шил
7. Бор картон
8. Бичгийн цаас орно

"Царцаа ногоон" үйлчилгээ 2018 онд бий болсноосоо хойш 1,000 гаруй айл өрх, 10 орчим аж ахуйн нэгжид хүрч ажиллаж байгаа бөгөөд нэг жилийн хугацаанд нийт 3 тонн орчим дахивар цуглуулсан байна. Үүнээс 1.5 тонн орчим нь хуванцар, гялгар уут байсан байна.



“Царцаа ногоон” үйлчилгээний авдаг дахивар ангиллын төрөл



Хог хаягдлыг дахин боловсруулснаар маш олон төрлийн хэрэгтэй бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой байдаг. Одоогийн байдлаар МУ-ын хэмжээнд дахин боловсруулах 23 үйлдвэр байгаагийн ихэнх нь ахуйн хог хаягдлыг дахин боловсруулдаг. Дараах хүснэгтэд Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй зарим үйлдвэрүүдийн мэдээллийг нэгтгэж оруулав.

Дахивар хаягдал авч, боловсруулж буй аж ахуйн нэгжүүдийн мэдээлэл

Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны төрөл	Байршил	Холбоо барих
1	Мог пластик ХХК	HDPE, LDPE, PP Хаягдал хуванцар дахин боловсруулах	Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг	99102165 contact@mog.mn
2	Од пластик ХХК	Хаягдал хуванцар, хагас боловсруулсан бэлдэц үйлдвэрлэх	Улаанбаатар, Баянгол дүүрэг	
3	Сайн цаас ХХК	Хаягдал картон цаас дахин боловсруулах	ХУД, Яармаг, СХД	75111896
4	Аминболор ХХК	Бүх төрлийн хоёрдогч түүхий эдийн бөөний төв	Улаанбаатар, Сонгинохайрхан	
5	Тэр их нуур ХХК	Вакум цонхны хаягдлаар PVC хуванцар хоолой үйлдвэрлэх	Улаанбаатар хот, СБД	91917077, 98087077



Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны төрөл	Байршил	Холбоо барих
6	Инахис ХХК	Автомашин хаягдал дугуйн хаягдлаар резинэн хавтан үйлдвэрлэх үйлдвэр	Улаанбаатар, Чингэлтэй	Утас: 99115097, mongolrubber@gmail.com
7	Пластик центр ХХК	Хаягдал гялгар уутыг дахин боловсруулах үйлдвэр	Улаанбаатар,	91019081,88104308
8	Хэв хашмал хуванцар ХХК	Хоёрдогч хуванцар бүтээгдэхүүнийг дахин боловсруулж барилгын угсралтад өргөнөөр хэрэглэгддэг арматур хөндийрүүлэгч, зай баригч, ханын сэнсэн хөндийрүүлэгч зэрэг бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх	Улаанбаатар, Баянзүрх	95159020, 96499020, 70169020
9	Төвшин сайхан төв ХХК	Хаягдал түүхий эд хүлээн авах төв	Улаанбаатар, Баянзүрх	9668-5858, 8813-0083
10	Сан-Оргиу ХХК	Ус ундааны хуванцар сав, гялгар уут ашиглаж хашаа, сандал, хогийн сав, хуванцар шон зэрэг хот тохижилтын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг үйлдвэр		99107809
11	Ахуй мандал ХХК	Төрөл бүрийн автомашины хаягдал дугуй, резин, хуванцар, уул уурхайн техник хэрэгсэл болон автомашины хаягдал тос, тосол буюу ажилласан тосыг боловсруулж, чанар, стандартын шаардлага хангасан дизель түлш, бензин үйлдвэрлэдэг	Багахангай дүүрэг	
12	Элэмент ХХК	Аюултай хог хаягдал тээвэрлэх, Аюултай хог хаягдал цуглуулах, Аюултай хог хаягдал устгах,	Улаанбаатар, Сонгинохайрхан	З.Баярсайхан, Ерөнхий захирал, 99193790
13	Цэцүүх трейд ХХК	Химийн бодисын ашиглагдсан полиэтилен канистр, торх, ИВС танк, полипропилен уут шуудай, баглаа боодлыг дахин боловсруулж хуванцар үрлэн түүхий эд үйлдвэрлэх		Доржийн Бямбасүрэн, Менежер, 99057704, 70179777



Д/д	Аж ахуйн нэгжийн нэр	Үйл ажиллагааны төрөл	Байршил	Холбоо барих
		эко үйлдвэр		
14	"Хай Би Ойл" ХК	Ашигласан тос дахин боловсруулах үйлдвэр	Улаанбаатар, Сонгинохайрхан	Шарав Амар-Отгон, Гүйцэтгэх захирал, 88119740, 99904034, 91997527

Хог хаягдлаа ангилан ялгаж эдгээр үйлдвэрүүдэд тушааснаар хог хаягдлаа эдийн засгийн эргэлтэнд оруулж, улмаар байгууллагын дотоод зардал тодорхой хэмжээгээр буурах боломж бүрдэх юм.



5 ХОГ ХАЯГДЛААС БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ

Суурин газруудад хүн ам, үйлдвэрлэл, үйлчилгээний төвлөрөл ихэссэний улмаас хог хаягдлыг энд тэндгүй ангилан ялгалт хийлгүйгээр бөөгнүүлж хаях, булах, шатаах зэргээр зайлуулж байна. Энэ нь тухайн орчны агаар, ус, хөрс, газрын гадаргыг бохирдуулж, гэдэсний халдварт өвчин, сүрьеэ, боом, татран зэрэг өвчний эх үүсвэр болдог. Хамгийн түгээмэл тохиолддог сөрөг нөлөөллүдийг дурдвал:

Нөлөөлөл-1. Байгалийн унаган төрх алдагдах, бохирдох.

Хогийн овоолго нь үржил шимтэй газрыг бохирдуулж, тухайн орчны ургамал, амьтны аймгийг үхэлд хүргэж, ойролцоох суурингууд руу тэлж, хүмүүсийн эрүүл мэндэд эргээд нөлөөлөл үзүүлж, хордуулдаг байна.



Нөлөөлөл- 2. Орчин тойронд таагүй үнэр тархах.

Хог хаягдлыг ялган ангилалт хийлгүйгээр ялзрах муудах хаягдалтай хамт нийлүүлэн хаяж, зайлуулалгүй удаан байлгаснаар ялзарч өмхийрөх ба хог хаягдлаас ялгарах аммиак, хүхэрт устөрөгчийн хурц, муухай үнэр нь орчиндоо тархаж эргэн тойрны хүмүүст төвөг учруулдаг.



Нөлөөлөл- 3. Нян бактери үржих.

Органик гаралтай хог хаягдал нь хурдан ялзардаг ба энэ нь шавж, мэрэгч амьтад цугларч халдварт өвчин үүсгэх, тархах эх үүсвэр болдог.





Нөлөөлөл- 4. Экологийн тэнцвэр алдагдах.

Хог хаягдлыг хэт их бөөгнөрүүлэх, хөрсөнд булшлах зэрэг нь эргээд тухайн орчиндоо экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулах эрсдэлтэй.



Нөлөөлөл -5. Агаар бохирдуулах.

Булж дарсан хог хаягдлыг нөхөн сэргээх, дахин боловсруулах боломжгүй бөгөөд хэдэн зуун жилийн турш тэд хүрээлэн буй орчноо хорт утаагаар хордуулдаг. Түүнчлэн хог хаягдлыг шатаах нь мөн хор ялгаруулдаг байна. Хог шатаахад цаг уурын өөрчлөлтөнд нөлөөлөгч хүлэмжийн хийг үйлдвэрлээд зогсохгүй хогонд агуулагддаг хорт бодисууд задарснаар бүр ч илүү хортой молекулуудыг үүсгэдэг болохыг нотолсон байдаг. Диоксин болон фуран ингэж үүсдэг бөгөөд эрдэмтдийн үзэж байгаагаар эдгээр нь хамгийн хортой нэгдлүүд юм.



Нөлөөлөл -6. Хөрс бохирдуулах

Одоогоор манай оронд ихэвчлэн ангилагдаагүй хогийг булж устгаж байна. Гэвч энэ нь доошоо хөрсний бохирдол үүсгэж, улмаар газрын доох усыг ч бохирдуулах боломжтой юм. Ус бохирдсоноор хүний эрүүл мэндэд дам сэрэг нөлөө үзүүлж гэдэсний халдварт өвчин, сүрьеэ, боом, татран зэрэг өвчний эх үүсвэр болдог.





Хог хаягдлын байгаль дээр задралд орох хугацаа






Үндсэн хог хаягдал нь БО-д хэрхэн сөрөг нөлөөтэй ямар хугацаанд задардаг тухай дараах хүснэгтээр үзүүлэв.

Хог хаягдлын төрөл	Хөрсөнд задрах жил	Сөрөг нөлөөлөл	Тайлбар зураг
Тамхины иш	10-12 жил	Ихэнх тамхины шүүлтүүр нь целлюлозын ацетат хэмээх байгалийн бодисыг өөртөө агуулдаг. Энэхүү бодис нь байгальд хаягдсан тамхины ишэнд бий болсноор задрах үйл явцыг улам удаашруулдаг байна. Удаан хугацааны дараа задарч эхэлдэг тамхины иш, шүүлтүүрүүдээс никотин, арсеник, хар тугалга гэх мэт бодис байгальд ялгардаг. Далай тэнгис дэх амьтад тэрхүү ялгарсан хорт бодисуудаар хооллосноор бидний хүнсэнд хэрэглэдэг далайн гаралтай бүтээгдэхүүнээр дамжин хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх боломж бүрддэг	
Бохь	5 жил	Бохь нь хүний биед аюулт өвчин үүсгэгч хамгийн хортой бодисуудын нэгдэл аж. Хамгийн нэртэй брэнд бохины найрлаганд ч сорбитол, ксилитол, маннитол, мальтитол, бохины үндэс, глицерол, байгалийн болон хиймэл амт оруулагч, аспартам-ацесульфам, будагч бодис, техникийн ионол, хүчил агуулагддаг байна.	
Хуванцар сав	400-1000 жил	Хуванцар нь полившил (pvc гэгддэг) болон полиэтиленээс тогтоно. Хуванцар саван дахь химийн бодисууд амьтны дотор эрхтэн, арьс, үсээс гадна хүний мэдрэлийн эсийг гэмтээдэг нь нотлогдсон. Хуванцар хог хаягдал нь өөртөө маш олон төрлийн бичил биетнүүдийг агуулдаг бөгөөд биологийн аргаар задрахдаа эдгээр бичил биетнүүд нь дэлхийн дулааралд нөлөөлөхүйц метан /хүлэмжийн/ хийг ялгаруулдаг.	








Хог хаягдлын төрөл	Хөрсөнд задрах жил	Сөрөг нөлөөлөл	Тайлбар зураг
Гялгар уут	200-1000 жил	Гялгар уут нь агаар, усны гэх мэт гадны нөлгөөр задардаггүй, уусдаггүй, ууршдаггүй болхоор газрын хөрсөнд задралгүй уддаг. Түүнээс гадна газрын өнгөн хөрсний хамгийн шим тэжээл бүхий ургамлын үндэс, бичил амьд биетүүдийн амьсгалах, нарны гэрлийг хүлээн авах замд хортой нөлөө үзүүлж, тэр хэсэгтээ үхжил үүсгэдэг зэрэг хүрээлэн буй байгаль орчинд хор уршигтай.	
Хүүхдийн живх	500-600 жил	Живх хэрэглэснээр хүүхэд крипторхизм хэмээх өвчнөөр өвчлөх өндөр магадлалтай болдог байна. Түүнчлэн живх нь хөрсөн дээр 500-600 жил хүртэл хугацаанд задрахгүйгээр байгаль орчныг бохирдуулдаг.	
Нэг удаагийн хэрэглээ	250-400 жил	Нэг удаагийн аяга, таваг зэрэг нь цаасаар хийсэн тул байгаль халгүй гэж хэлж болох авч нөгөө талаасаа бол үрэлгэн хэрэглээнд орно. Та бидний 50 грамм кофе, эсвэл 100 грамм кока кола уучихаад хогийн сав руу шиддэг тэр нэг удаагийн аягануудыг хийхийн тулд хэчнээн ногоон модыг огтолж, хэдэн тонн ус, хэдэн кВт эрчим хүч зарцуулж байгаа вэ гэдгийг тооцох юм бол хэрэглээнээсээ хэд дахин өндөр тоо гарна.	
Шил, шилэн лонх	4000 жил	Шил нь элс (SiO_2), сода (Na_2CO_3), шохойн чулуу ($CaCO_3$), доломит ($CaCO_3 \cdot MgCO_3$) болон натрийн сульфат (Na_2SO_4) зэргээс тогтдог. Шил байгаль орчиндоо ноцтой асуудал үүсгэлгүйгээр тодорхой цаг хугацааны явцад уусан шингэдэг. Хэрэв шил нь халуун болон хүчлийн үйлчлэлгүй бол байгалийн бүтээгдэхүүн болж задрах хугацаа уртасна.	



Хог хаягдлын төрөл	Хөрсөнд задрах жил	Сөрөг нөлөөлөл	Тайлбар зураг
Хөнгөн цагаан лааз	50-100 жил	200 микроны зузаантай хөнгөнцагаан лаазны бүтцэд тугалга байдаг. Түүнд агуулагдах тугалга зэвэрч, буцаад байгалийн бүтээгдэхүүн болдог бол хөнгөнцагаан нь 100 жилийн хугацаанд хүчилтөрөгч болон борооны үйлчлэлээр задардаг.	
Ариун цэврийн цаас	2-4 долоо хоног	Ариун цэврийн цаас үйлдвэрлэгчид цаасыг үйлдвэрлэхийн тулд маш олон төрлийн химийн найрлага бүхий бодис хэрэглэдэг. Хамгийн хортой бодис болох хлор болон хлорын давхар ислийг модны бор өнгийг цайруулахын тулд ашигладаг байна. Энэ үйл явцын үр дүнд химийн хорт бодис болох диоксин, фураныг ялгаруулдаг. Диоксин нь хүн төрөлхтний бүтээсэн хамгийн хортой химийн бодисын нэг юм байна. Энэхүү бодис урт хугацааны турш хүний биед хадгалагдаж байдгаас хорт хавдар, ургийн гажиг, дааврын тэнцвэргүй байдал үүсгэх, дархлалын системийг гэмтээх, ядраах зэрэг биед маш муугаар нөлөөлдөг байна.	
Сонин	1.5 сар	Дэлхий дээр жилд дунджаар 15 сая га модыг устгаж байгаагийн 1/3 нь цаас үйлдвэрлэхэд зарцуулагддаг. Нэг тонн бор цаас гаргаж авахад 17 ширхэг мод ашигладаг. 17 модноос цаас гаргаж авахын тулд 26 500 литр ус зарцуулдаг.	
Мод, модон эдлэл	3-10 жил	Модон материалын хаягдал нь дахин ашиглагддаг хаягдал.	
Хуучин арьсан гутал хувцас	25-40 жил	-	



Хог хаягдлын төрөл	Хөрсөнд задрах жил	Сөрөг нөлөөлөл	Тайлбар зураг
Бэлэн хоолны сав	Устдаггүй	Бэлэн гоймонд ихээр ашигладаг полимер буюу хөөсөн хуванцар сав газарт хаягдвал хөрсөнд задардаггүй, устдаггүй байна.	
Тэтрапак сав	5 жил	-	
Ноосон эдлэл, нийлэг даавуу	5 -40 жил	-	
Олс уяа	1.5 жил	-	
Төмөр	110-130 жил	-	
Тоосгоны үлдэгдэл	100 жил	Ойр орчимд нарийн тоос дэгдээх, үзэгдэх орчин бууруулах, улмаар хүний эрүүл мэндэд шууд нөлөөлнө.	



Хог хаягдлын төрөл	Хөрсөнд задрах жил	Сөрөг нөлөөлөл	Тайлбар зураг
Машины аккумулятор	100 жил	Аккумуляторын ашиглалтын хугацаа дууссан тохиолдолд их хэмжээний хорт бодис тархаж хүн мал, хүрээлэн байгаа орчинд багагүй хор хөнөөл учруулдаг.	 <small>www.caak.mn</small>
Зай	110 жил	Зай, гар утасны батерэйг ямар ч хяналтгүй ил задгай хаягдаж байгаа нь хүний эрүүл мэндэд болон байгаль орчинд асар их сөрөг нөлөөлтэй. Олон хорт бодис агуулсан зай газрын хөрсөнд шигдэж, илжирч, агаарт уусан задарч бид түүгээр нь амьсгалдаг. Нэг ширхэг жижигхэн хуруу зай дөрвөн метр квадрат талбай хордуулж, 800 мянган литр ус бохирдуулдаг хор уршигтай.	 <small>www.ccaak.mn</small>
Дугуй	120-140 жил	Дугуйны хаягдал нь шатамхай материал бөгөөд шатсан тохиолдолд ойролцоо байгаа бүх хүмүүст хордлогын эрсдэл учруулж болзошгүй. Учир нь резин нь шаталтын үед хорт хавдар үүсгэгч хорт бодис ялгаруулдаг.	 <small>www.ccaak.mn</small>



6 ДҮГНЭЛТ

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн 3-р хорооны нутаг дэвсгэрт орших Дулааны 3-р цахилгаан станцын Техникийн бодлогын хэлтсийн санаачлагаар хог хаягдлын менежментийг сайжруулах зөвлөмж, гарын авлага боловсруулах ажлыг “ДЦС-3” ТӨХК-тай байгуулсан гэрээний дагуу 09 сарын 04-ий өдрөөс 23-ны өдрийг дуусах хугацаанд хийж гүйцэтгэлээ.

Уг зөвлөмж, гарын авлагыг боловсруулах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэв.

1. Өнөөгийн байдлаар гарч буй ахуйн хог хаягдлын төрөл, хэмжээ, зайлуулж буй арга хэлбэр зэрэг мэдээллүүдтэй танилцаж үйлдвэрийн ажилчдын тоо, байгууламжуудын байршлаас хамааруулан хог хаягдлын ангилалын тоо, төрөл, хог хаягдал түр хадгалах цэгийн байршлуудыг сонгож, түүний загвар хийцийг санал болгосон.
2. Хог хаягдлаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг тодорхойлон тухайн хог хаягдал хөрсөнд задран, шингэх хугацааг түүвэрлэн бэлтгэсэн.
3. Төслийн үйл ажиллагаатай уялдуулан хог хаягдалтай холбогдох даган мөрдвөл зохих хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн орчныг түүвэрлэн бэлтгэв.
4. Хог хаягдлын ангилан ялгах төрлийг тодорхойлж түүнээс дахивар хог хаягдлыг боловсруулах аж ахуйн нэгжүүдийн мэдээллүүдийг нэгтэн бэлтгэсэн.

Энэхүү зөвлөмжид заасны дагуу хог хаягдлыг эх үүсвэр тус бүр дээр ангилан ялгаж, төрөлжүүлэн, улмаар ажилчдад хэвшүүлэх арга хэмжээг богино хугацаанд хэрэгжүүлсэн тохиолдолд ДЦС-ын хог хаягдлын менежмент аажимдаа сайжирч, байгууллагын хог хаягдалтай холбоотой дотоод зардал тодорхой хэмжээнд буурч, нийгмийн хариуцлагын хүрээнд байгальд сөрөг нөлөө багатай үйлдвэр, байгууллага нэгээр нэмэгдэх бүрэн боломж байна.